

## **ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

### **АЙМГИЙН ЗУРГААН СУМЫН ЦАГДААГИЙН ТАСАГ, ХЭСЭГ АВТОМАШИНТАЙ БОЛЛОО**

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр сумдын Цагдаагийн тасаг, хэсэгт зургаан автомашиныг хүлээлгэж өгөх арга хэмжээ зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, ГХУСАЗСЗ-ийн дарга Л.Хишигтогтох, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, аймгийн Цагдаагийн газрын дарга Т.Ганзориг нар оролцсон.

Сумдын Цагдаагийн хэсэгт ард иргэдийн амар тайван, аюулгүй орчин бүрдүүлэх, иргэдийн дуудлага мэдээлэлд хурдан үйлчлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг, Хөлөнбуйр, Баян-Уул, Цагаан-Овоо, Чойбалсан, Сэргэлэн сумдын Цагдаагийн хэсэг автомашинтай болж байна.

Энэ онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр сумдын цагдаагийн байрыг засварлах, малын хулгайтай тэмцэх зорилгоор хэсгийн төлөөлөгч нарт 30 гаруй сая төгрөгийн шатахууны дэмжлэгийг үзүүлээд байна.

**Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан** Монгол дайчдын хөшөөнд мөнхийн гал асааж, цэцэг өргөж хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох, Засаг дарга М.Бадамсүрэн, Ахмад дайчин н.Өсөх гуай болон бусад албаны хүмүүс оролцлоо.

Манай улсын түүхэнд Чөлөөлөх дайн гэж нэрлэдэг энэ дайнд Монгол Ардын хувьсгалт цэрэг, ЗХУ-ын арми хамтран ялгуулсан ялалт байгуулж 6 жил нэг өдөр үргэлжилсэн дайныг цэглэж, Монголын цэрэг дайчин эрс дэлхийд энх тайвныг бүтээлцсэн түүхтэй.

### **УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГСДИЙН ДУРСГАЛЫГ ХҮНДЭТГЭХ, ТЭДНИЙ АР ГЭРТ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

Монгол Улс жил бүрийн есдүгээр сарын 10-ныг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр болгон тэмдэглэж ирснээс хойш 25 жил болж байна.

Энэ өдрийг тохиолдуулан Данригданжаалин хийдэд буяны ном хуруулж, Гүсэн тугийн мандал өргөж, 108 зул бадраасан ба энэхүү арга хэмжээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Хишигтогтох, Засаг дарга М.Бадамсүрэн нар болон бусад албаны хүмүүс, хэлмэгдэгсдийн үр хүүхэд, ач зээ нар оролцлоо

2018 онд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулинд өөрчлөлт орж хэлмэгдэгсдийн үр хүүхдэд 40-80 сая төгрөг олгож байна. одоогийн байдлаар Дорнод аймагт 50 гаруй иргэнд 3 тэрбум 400 сая гаруй төгрөгийн нөхөн олговор олгоод байна.

Монгол Улс жил бүрийн есдүгээр сарын 10-ныг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр болгон тэмдэглэж ирснээс хойш 25 жил болж байна.

Энэхүү өдрийг тохиолдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Хишигтогтох Улсын Тэргүүний 1 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчдад “МОНГОЛ ДАХЬ ИХ ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ” сэдвээр хичээл орлоо

Зүүн бүсийн Төр, хувийн хэвшлийн зөвлөлийн анхдугаар чуулган амжилттай болж өндөрлөлөө

Зүүн бүсийн Төр, хувийн хэвшлийн зөвлөлийн анхдугаар чуулган болж зүүн 3 аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн зорилтыг хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн бодлого боловсруулахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх болон олон асуудлаар санал бодлоо солилцлоо.

Чуулганд Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар, Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Сүхбаатар аймгийн ИТХ-ын дарга Мөнхбат, Хэнтий аймгийн ИТХ-ын дарга Батсайхан болон бусад албаны хүмүүс, төслийн баг хамт олон, аймгуудийн Төр хувийн хэвшлийн зөвлөлийн гишүүд оролцлоо.

Монгол улсын Засгийн газрын санаачлага, Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгээр дэвшилтэд технологи, инновацид суурилсан, өрсөлдөх чадвартай хувийн хэвшлийн салбарыг Монгол улсын Зүүн бүсэд бий болгох зорилгоор хэрэгжиж буй “Зүүн бүсийн аймгуудын эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Төр, хувийн хэвшлийн зөвлөл байгуулсан.

Монгол улсын Засгийн газрын санаачлага, Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгээр дэвшилтэд технологи, инновацид суурилсан, өрсөлдөх чадвартай хувийн хэвшлийн салбарыг Монгол улсын Зүүн бүсэд бий болгох зорилгоор хэрэгжиж буй “Зүүн бүсийн аймгуудын эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Төр, хувийн хэвшлийн зөвлөл байгуулсан.

## ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР 5 ИРГЭН ЭНГЭРЭЭ МЯЛААЛАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 227 дугаар зарлигаар тус аймгийн Төр, захиргаа, Эрүүл мэнд, боловсрол, Хөдөө аж ахуйн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, аймаг, орон нутгийнхаа бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулсан 5 иргэнд Монгол Улсын төрийн дээд одон медалийг өнөөдөр /2020.09.25/ гардууллаа.

Шагналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Хишигтогтох гардуулж, баяр хүргэлээ.

Алтан гадас одонгоор Булган сум 4-р багийн МУ-ын аварга малчин Г.Оюунсүрэн, БОЭТ-ын ахмад сувилагч Д.Сугар, Хэрлэн сумын ахмад настан Ч.Цэндхорлоо, Хөдөлмөрийн хүндэт медалиар ХХҮГ-ын мэргэжилтэн Б.Оргилсайхан, алдарт эхийн одонгоор Ц.Ариунчимэг нар тус тус шагнагдаж, энгэрээ мялаалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 227 дугаар зарлигаар төрийн шагналаар шагнагдсан боловч шагнал гардуулах арга хэмжээний үеэр хүндэтгэн үзэх шалтгаанаар шагналаа гардаж авч чадаагүй эдгээр иргэдэд ийнхүү шагналыг гардууллаа.

### Хоёр. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн төр, нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын Удирдах ажилтны шуурхай хуралдааныг 09 дугаар сард батлагдсан хуваарийн дагуу нийт 2 удаа зохион байгуулсан.

### ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:

Орон нутгийн нийторлого 63100.1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 59691.0 сая төгрөг, үүнээс татварын орлого 15244.7 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 13911.8 сая төгрөгт хүрч 1332.9 сая, татварын бус 47855.4 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 45779.2 сая төгрөгт хүрч 2076.2 сая тус тус төгрөгөөр тасарлаа.

### Орон нутгийн төсвийн нийт орлого

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	63,100,078,000.00	59,691,001,711.64	(3,409,076,288.36)	94.60
003 ТАТВАРЫН ОРЛОГО	15,244,685,400.00	13,911,769,355.17	(1,332,916,044.83)	91.26

004	Орлогын албан татвар	8,758,619,000.00	9,086,523,030.42	327,904,030.42	103.74
016	Хөрөнгийн албан татвар	877,076,600.00	883,637,991.76	6,561,391.76	100.75
021	Бусад татвар, төлбөр, хураамж	5,608,989,800.00	3,941,608,332.99	(1,667,381,467.01)	70.27
041	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,855,392,600.00	45,779,232,356.47	(2,076,160,243.53)	95.66
042	Нийтлэг татварын бус орлого	2,838,620,900.00	2,637,588,781.47	(201,032,118.53)	92.92
049	Хөрөнгийн орлого	0.00	46,163,760.00	46,163,760.00	
056	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	34,700,818,200.00	33,344,212,845.00	(1,356,605,355.00)	96.1
058	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	29,727,038,300.00	29,727,038,300.00	-	100.0
059	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	4,973,779,900.00	3,617,174,545.00	(1,356,605,355.00)	72.7

#### ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 66883.9 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 55197.0 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Нийт төсвийн зарлагын

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 58,5%
- ✓ Тогтмол зардалд 18,3%
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 9,8%
- ✓ Хөрөнгийн зардалд 13,4% байна.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 5800.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 29727.0 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ.

#### Орон нутгийн төсвийн нийт зарлага

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,663,789,500.00	49,009,684,269.78	(10,654,105,230.22)	82.1
Цалинхөлсболоннэмэгдэлурамшил	28,942,862,000.00	25,916,403,310.05	(3,026,458,689.95)	89.5

Ажиллолгогчооснийгмийндаатгалдтө лөхшимтгэл	3,780,005,100.00	3,261,004,236.05	(519,000,863.95)	86.3
Бараа үйлчилгээний бусад зардал	4,706,401,700.00	2,897,921,935.75	(1,808,479,764.25)	61.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,782,332,300.00	1,155,704,373.87	(626,627,926.13)	64.8
<b>Б. ХӨРӨНГИЙНЗАРДАЛ</b>	13,510,695,200.00	8,761,498,926.80	(4,749,196,273.20)	64.8

ЖИЧ: Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээлэлийг Аймгийн ЗДТГ-ын № 15 тоот өрөө, [www.dornod.gov.mn](http://www.dornod.gov.mn) вэб сайт, 70583034, 70582372 дугаарын утсаар авч болно

### **Тав. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

***Нэг. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Биеийн тамир, спортын газар***

***Нэг. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Биеийн тамир, спортын газар***

### **Улс, бүсийн чанартай уралдаан, тэмцээн:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан хөлбөмбөгийн 21 аймгийн аварга шалгаруулах тэмцээнд ахлах дасгалжуулагч Л.Наранбаатараар удирдуулсан хөлбөмбөгийн насанд хүрэгчдийн шигшээ баг хүрэл медаль хүртсэн.

Хөнгөн атлетикийн өсвөр үе, насанд хүрэгчид, ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотын Налайх дүүрэгт зохион байгуулагдаж Дорнод аймгаас нийт 24 тамирчин оролцож, өсвөр үеийн УАШТэмцээнд 1 алт, Насанд хүрэгчдийн УАШТэмцээнд 1 хүрэл, Ахмадын УАШТэмцээнд 1 алт, 4 мөнгөн медаль тус тус хүртсэн. Дорнод аймгийн Хэрлэн сумын харъяат Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн тамирчин, ОУХМ Б.Мөнхзаяа 500 метрийн гүйлтэд Монгол Улсын рекордыг шинэчлэн тогтоосон.

Насанд хүрэгчдийн волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд Дорнод аймгийн эрэгтэй баг тамирчид хэсэгтээ 2 хожиж, 1 хожигдож хагас шигшээд шалгарсан.

Монголын Хөл Бөмбөгийн Холбооны “Үндэсний Нэгдүгээр Лиг 2020” тэмцээнд Дорнод аймгаас ахлах дасгалжуулагч Л.Наранбаатар “Эвт Хөх Чоно” багийг ахлан лигийн тэмцээнд амжилттай оролцож байна.

Идэрчүүдийн улсын аварга шалгаруулах волейболын тэмцээнд биеийн тамир, спортын газрын дасгалжуулагч Ч.Мөнхбатаа, ОУХМ Г.Энхмягмар нараар удирдуулсан охид, хөвгүүдийн баг нийт 24 тамирчин оролцов.

“Сокол” ХХК-ийн нэрэмжит Бадминтон сонирхогчдын насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн Эрдэнэт хотод зохион байгуулагдан нийт 13 байгууллагын 206 тамирчин 4 насны ангиллаар өрсөлдөж, Дорнод аймгаас 14 тамирчин оролцож 3 алт, 3 мөнгө, 2 хүрэл медаль тус тус хүртсэн. Багийн дүнгээр 4-р байранд шалгарсан.

Ширээний теннисний ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, 90 багийн 500 гаруй тамирчид 4 насны ангиллаар өрсөлдөж, Дорнод аймгийн 14 тамирчин оролцов.

Улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд нийт 163 тамирчин оролцож 8 алт, 4 мөнгө, 4 хүрэл медаль авлаа.

#### **Аймаг орон нутагтаа зохион байгуулсан биеийн тамир, спортын арга хэмжээ:**

Дорнод аймгийн Сурын холбооноос 2020 оны Отго харвааг Чойбалсан хотын Сурын талбайд зохион байгуулсан. Отго харваа буриад сур, үндэсний сурын эрэгтэй, эмэгтэй төрлөөр зохион байгуулагдсан бөгөөд буриад сурын харваанд 21, үндэсний сурын харваанд 28 харваач сэц мэргэнээ сорин өрсөлдөж, шилдгүүдээ тодруулав.

#### **Сургалт, семинар:**

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэс болон Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” аймаг орон нутгийн болон хотын дүүргийн агентлаг, байгууллагуудын хүний нөөц, дотоод ажил хариуцсан албан хаагчдын цахим сургалтад 1 албан хаагч хамрагдав.

#### ***Хоёр. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл, урлагийн газар***

#### **Сургалт, зөвлөгөөн:**

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газраас “Багш нарын баяр” угтсан ажлын хүрээнд “Боловсролын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлого”, “Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль”, “Жендэрийн үндэсний хөтөлбөр”- ийн хэрэгжилтийг хангах, байгууллагынхаа үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, төсөвлөх зэрэг ойлголт, мэдлэгийг

нэмэгдүүлэхэд чиглэгдсэн “Жендэрийн ахисан түвшний дүн шинжилгээ” цахим сургалтад цэцэрлэгийн 27 эрхлэгч, Ерөнхий боловсролын сургуулийн 20 нийгмийн ажилтныг тус тус хамруулсан.

Цахим сургалтын 1 дэх шатны сургалтад 20, 2 шатны сургалтад 18 нийгмийн ажилтан хамрагдсан бөгөөд уг сургалтыг түгээх, багш, ажилтны мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 12 сургуулийн 383 багш, 56 ажилтан, нийт 439 багш, ажилтныг хамруулж мэдлэг, ойлголттой болгосон байна.

Нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ, үйл ажиллагаанд баримтлах үнэт зүйлс, зарчим, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах, нийгмийн хөгжил, хүн, хүүхдийн эрхийг хангах зэрэг нийгмийн бүх салбарт шууд ба шууд бус үйлчилгээг үзүүлэх, нийгмийн ажлын олон талт үйлчилгээг хүргэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хамтарсан багийн үйл ажиллагаан дахь оролцоог нэмэгдүүлэхэд шаардлагатай үндсэн ойлголт өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, чадавхжуулах зорилгоор сургалт зохион байгуулсан.

#### **Арга зүйн ажил:**

Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр хийгдэж байгаа ажлуудын мэдээлэл туршлага солилцох зорилгоор арга зүйн ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 08-нд аймгийн төвийн 13 нийгмийн ажилтан, Баянтүмэн, Булган, Чойбалсан, Сэргэлэн, Матад, Баян-Уул, Дашбалбар сумын сургуулийн нийгмийн ажилтнууд танхимаар, Баяндун, Халхгол, Ялалт баг, Хөлөнбуйр, Гурванзагал Цагаан-Овоо, Чулуунхороот, сумын сургуулийн нийгмийн ажилтнууд цахимаар холбогдож, зохион байгуулсан. Нийт 24 нийгмийн ажилтан хамрагдсан.

#### **Мэдээллийн сан бүрдүүлэлт:**

“Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сан”-г яамны садын баталсан маягтын дагуу бүрдүүлж мэдээллийн нэгдсэн цахим сантай боллоо. Аймгийн 27 сургуулиас 21 сургууль сан бүрдүүлсэн мэдээллийг ирүүлсэн бөгөөд “Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сан нь” хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх, мөн үйл ажиллагааныхаа албан хэрэгцээндээ ашиглах, хэрэглэхэд чиглэгддэг учиртай.

Нийгмийн ухааны багш, нийгмийн ажилтнуудын дэлгэрэнгүй судалгааг холбогдох хүмүүсээр нь хүргэсэн маягтын дагуу гаргуулан хянаж, нэгтгэл хийсэн. Энэ хичээлийн жилд нийгмийн ухааны Баян-Уул, Хэрлэн сумын 8 дугаар, Шинэ хөгжил, Дорнод ахлах сургуульд нийгмийн ухааны багш, Матад сумын сургуульд нийгмийн ажилтан шинээр ажилд орсон байна. Мэргэжлийн багш нарын хангалт 100%, харин

Ерөнхий боловсролын 23 сургуульд 27 мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллаж байгаа бөгөөд мэргэжлийн хангалт 96,2%-тай, Чулуунхороот сумын сургуульд өөр багш мэргэжилтэй хүн ажиллаж байгаа бөгөөд ДИС-д хөрвөх сургалтад хамрагдаж байгаа болно.

### **Зөвлөн туслах үйл ажиллагаа:**

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа, хичээл эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай болон холбогдох хууль тогтоомж, тушаал, шийдвэрийн хэрэгжилттэй танилцаж, зөвлөмж чиглэл өгөх, сургуулийн удирдлага, багш ажилтнуудад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор холбогдох мэргэжилтнүүд Халхгол, Ялалт, Матад, Баянтүмэн, Булган, Хөлөнбуйр, Баяндун, Сэргэлэн, Гурванзагал, Дашбалбар сумын сургууль, цэцэрлэгт ажиллаж, өвөлжилтийн бэлэн байдал, хичээлийн жилийн бэлэн байдлын хэрэгжилтэд хяналт тавьж, бэрхшээл, зөрчлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн.

### **Туршлага судлах үйл ажиллагаа:**

“Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”-ийн хүрээнд тус газраас хэрэгжүүлж буй “Хамтын хөгжил-манлайлал” төслөөр Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын бага боловсролын сургалтын менежерүүдийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор сургалт, аяллыг 2020 оны 09 дүгээр сарын 21-26-ны өдрүүдэд Улаанбаатар, Дундговь, Өмнөговь аймгуудад зохион байгуулсан. Туршлага судлах ажилд ерөнхий боловсролын сургуулиудын бага боловсролын 22 сургалтын менежер хамрагдсан.

### ***Гурав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар***

### **“Өргөдөл, гомдол”-ын шийдвэрлэлтийн мэдээлэл:**

Хүүхэд, гэр бүлийн эрх зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол, хүсэлт, хүүхдийн тусламжийн 108 утсаар нийт 11 дуудлагыг хүлээн авч хуулийн дагуу хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж ажилласан бөгөөд шийдвэрлэлт 70 хувьтай байгаа бөгөөд “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө” энэ сард нийт 4 хүүхэд, 1 насанд хүрэгчид давтамжтай зөвлөгөө үйлчилгээ авсан. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д энэ сард гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1 насанд хүрэгчийг хүлээн авч 5 хоногийн хугацаатай байршуулж, аюулгүй байдалд хяналт тавин эрүүл мэнд, сэтгэлзүй, хууль эрх зүйн болон холбон зуучлах, хамгааллын үйлчилгээг үзүүлэн харьяа хамтарсан багт шилжүүлж, үйлчлүүлэгчтэй ажиллах кейс төлөвлөгөө боловсруулан хариу үйлчилгээ үзүүлж байна.

Мөн гэр бүлийн асуудлаар хандсан 8 хүнд зөвлөгөө өгөхөөс гадна Дорнод аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийн дагуу гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж тогтоолгох 1 өрхийн хүсэлтийг хүлээн авч, үнэлгээ хийн шинжээчдийн дүгнэлтийг гарган хүргүүлсэн. Мөн үрчлэлтийн дүгнэлт хийгдэхээр ирүүлсэн 4 өрхийн нөхцөл байдлыг судлан дүгнэлтийг гаргаж, насанд хүрээгүй хохирогч хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр 4 шүүх хуралд оролцож, хүүхдийн эрхийг хамгаалан ажилласан.

### **Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:**

Хүүхэд эрүүл орчинд өсч бойжих аюулгүй орчинд амьдрах аливаа хүчирхийллээс ангид байх, сурч боловсрох эрх зөрчсөн насанд хүрээгүй 2 хүүхдийн асран хамгаалагчдын эцэг эх байх эрхийг хасуулах, хязгаарлуулах хүсэлтийг Дорнод аймгийн сум дундын шүүхэд гаргаснаар шүүх хурлаар эцэг эх байх эрхийг 6 сарын хугацаагаар хязгаарлуулж, хүүхдийг “Анна хоуме” асрамж, халамжийн төвд шилжүүлэн хүүхдийн эрхийг хамгаалсан. Мөн эцэг эхийн хараа хяналт гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй 2 хүүхдийг Улаанбаатар хотын “Өнөр бүл” хүүхдийн асрамж, халамжийн төвд хүлээлгэн өгч эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган ажилласнаар тайлант сард нийт 8 хүүхэд, 14 насанд хүрэгчдийн эрх, хамгаалын асуудлыг шийдвэрлэж ажилласан.

Хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас салбарын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй “Сүүдэр бүү тусга” соён гэгээрүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газартай хамтран аяны шторк, контентыг байгууллагын цахим хаягаар болон орон нутгийн телевизүүдээр дамжуулан иргэд олон нийтэд хүргэж байна. Аяны хүрээнд Хилийн 0132 дугаар ангийн 50 гаруй албан албан хаагчдад хүүхдийн эрхийн зөрчлийг мэдээлэх, гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийн талаарх сургалтыг зохион байгуулж, тэдний ойлголт мэдээллийг нэмэгдүүлсэн.

### **Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:**

Өсвөр үе, залуучууд, иргэдэд амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалтыг тогтмол явуулдаг бөгөөд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газрын эрүүлжүүлэх саатуулах байрны баривчлах байранд хүмүүжиж буй 60 иргэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 4, хорих ял эдэлж байгаа 4 залуучууд, хорихоос бусад ял шийтгэл болох тэнсэн харгалзах ял шийтгэлтэй 8 иргэн, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны 25 оюутан нийт 101 залуучуудыг сургалтад хамруулж, мэдлэг олгов.

Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд “Мэдлэгээ дээшлүүлж, мэдээллээ нэмэгдүүлэе” хууль сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж, Дорнод Их сургууль, Политехникийн коллеж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Ерөнхий

боловсролын сургуулиудын 11, 12 дугаар ангийн төлөөлөл, нийт 640 өсвөр үе, залуучуудад мэргэжил сонголтын зөвлөгөө, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээлэл, хорт зуршлаас татгалзах чиглэлийн мэдээллийг хүргэж, цаашид зохион байгуулах үйл ажиллагааны санал солилцож, төлөвлөлтөд тусгаад байна.

***Дөрөв. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Нийгмийн даатгалын хэлтэс***

**Нэг. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар:**

Нийгмийн даатгалын санд 2020 оны 09 дүгээр сард 17755764,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 22397438,30 мянган төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 126,1 хувиар биелүүлсэн байна. 2020 оны 09 дүгээр сарын мэдээгээр нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Нийгмийн даатгалын сангийн орлого /мянган төгрөг/

д/д	Төрөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Тэтгэврийн даатгалын санд	10983060,30	15236160,92	138,7
2	Тэтгэмжийн даатгалын санд	1087691,50	1568308,24	144,1
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд	915912,10	1398182,77	152,6
4	Ажилгүйдлийн даатгалын санд	199427,10	304155,33	152,5
5	Эрүүл мэндийн даатгалын сан	4569673,00	3890631,04	85,1
	Нийт	17755764,00	22397438,30	126,1

2020 оны 09 дүгээр сард нийт 613 ажил олгогч байгууллагын 4799 даатгуулагчийн 3,9 тэрбум төгрөг, 4801 сайн дурын даатгуулагчдын 667911,3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс (ЭМД-ын шимтгэлээс бусад) тус тус чөлөөлсөн.

**Хоёр. Тэтгэвэр тогтоолт, олголтын талаар:**

Аймгийн хэмжээнд 2020 оны 09 дүгээр сард шинээр нийт 64 иргэнд тэтгэвэр тогтоосон. Үүнээс:

- Өндөр насны тэтгэвэр 33, (малчин 6, хувь тэнцсэн 6, хүүхдээр 16, хүнд нөхцлөөр 2, цэргийн алба хаасны тэтгэвэр 3, хэвийн Өндөр насны 30)
- Тахир дутуугийн тэтгэвэр 24,
- Тэжээгч алдсны тэтгэвэр 7 тус тус тогтоосон.

Түүнчлэн 2020 оны 09 дүгээр сард нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас нийтдээ:

- Өндөр нас 9006,
- Тахир дутуу 2795,
- Тэжээгчээ алдсан 620,
- Цэргийн тэтгэвэр 605, нийт 13026 тэтгэвэр авагчдад 4989133,8 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон.

**Гурав. Тэтгэмж олголтын талаар:**

Тэтгэмжийн даатгалын сангаас:

- Хөлдөмөрийн чадвар түр алдсны тэтгэмж 286,
- Жирэмсэн, амаржсны тэтгэмж 155,
- Оршуулгын тэтгэмж 29 даатгуулагчид, нийт 505119,1 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон.

**Дөрөв. Ажилгүйдлийн тэтгэмж олголтын талаар:**

Аймгийн хэмжээнд 2020 оны 09 дүгээр сард нийт 113 даатгуулагчдад 56,7 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг бодож олгов. Энэ нь өмнөх сартай харьцуулахад 26 даатгуулагчийн 11 сая төгрөгөөр ажилгүйдлийн даатгалын зардал өссөн үзүүлэлттэй байна.

**Тав. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал:**

Уг сангаас нийтдээ 79 тэтгэвэр авагчдад нийтдээ 37280,98 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон байна. Рашаан сувиллын зардал 1 даатгуулагчид 379,0 мянган төгрөгийг олгосон.

**Зургаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр:**

2020 оны 09 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 934043,5 мянган төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 60,9 хувь буюу 569295,7 мянган төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага, 39,1 хувь буюу 364747,8 мянган төгрөгийг төсөвт байгууллагууд эзэлж байна. Нийт авлагын 39,8 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.

**Долоо. Ажилгүйдлийн даатгалын сангаас ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх талаар:**

Цар тахлын улмаас орлого нь 50 буюу түүнээс дээш хувиар буурсан ажил олгогч байгууллагад ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотойгоор ажилгүйдлийн даатгалын сангаас 69 ажил олгогч байгууллагын 1312 даатгуулагчид 26240,0 мянга төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.

**Найм. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаа:**

Шинэ коронавируст халвар (Covid 19) гарсантай холбогдуулан иргэдийг олноор цуглуулахгүй байх шийдвэр гарсантай холбогдуулан хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс цахим хурлаар 6 удаа хуралдаж, 333 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэснээс 19 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан, 279 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан, 35 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоосон байна.

Цуцлагдсан 19 иргэний 8 нь өндөр насны тэтгэвэр тогтоолсон, 7 нь заалтын хугацаа дууссан, 4 нь эмчлэн эрүүлжсэн иргэд байна.

**Ес. Дотоод ажил, сургалт сурталчилгаа, олон нийттэй харилцах чиглэлээр:**

2020 оны 09 дүгээр сард үдийн цайны цагаар 334 иргэнд, 1430 хүнд угтах үйлчилгээг үзүүлэн ажиллав. Түүнчлэн нээлттэй утас 70585955 утсанд хандсан 118 иргэн даатгуулагчид зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

Нийгмийн даатгалын хэлтсийн архиваас 49 даатгуулагчид лавлагаа олгохоос гадна бусад 4 аймаг, дүүргийн 10 иргэнд лавлагаа олгож, тэдний нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулсан.

Байцаагч ажилчдыг чадавхижуулах чиглэлээр онлайн сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

- “Сайн дурын даатгалын цахим үйлчилгээ” сургалтад 17 байцаагч,
- Сайн дурын даатгуулагч гэрээ байгуулах, сунгах, төлбөр төлөх зэрэг асуудлуудыг нийгмийн даатгалын апплекшейн ашиглан хийх боломжтой болсоныг иргэд даатгуулагчдад хэлтсийн пеж хуудсаар дамжуулан хүргэж байна.
- “Цахим архивын лавлагаа” сургалтад 6 байцаагч,
- 1995-2005 оны шимтгэлийн баримтыг цахимд оруулж улмаар даатгуулагчдын шимтгэл төлсөн хугацаа, цалингийн мэдээллийг цаасан баримт үзэж цаг алдах шаардлагагүй болсон.

***Тав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар***

**Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ:**

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, ажилгүйдэлд өртөж болзошгүй, их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль төгссөн 92 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгсөнөөс хөдөлмөрт бэлтгэх зөвлөгөөг 15 иргэн, хөдөлмөр эрхлэлтийн талаар 46 иргэн, мэргэжлийн талаар 9, мэргэжил сонголтын талаар 22 иргэнд зөвлөгөө өгөөд байна. Зөвлөгөө мэдээлэлд хамрагдсан иргэдийг насны ангиллаар авч үзвэл 15-24 насны 40 иргэн, 25-34 насны 28 иргэн, 35-44 насны 12 иргэн, 45-54 насны 11 иргэн, 60-аас дээш насны 1 иргэн тус тус хамрагдсан байна.

**Ажилд зуучлах үйлчилгээ:**

Тайлант сард 14 аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс 217 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлсний дагуу “Дорнод ажлын байр” хуудас болон хэвлэмэл хуудас, утсаар холбогдож, санал болгосноос 179 иргэнийг ажлын байранд зуучлаад байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл уул уурхай 5, усан хангамж, хог хаягдал 73, бөөний болон жижиглэн худалдаа 14, болосврол 71 үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 17 иргэн тус тус зуучлагдсан байна.

### **Бүртгэлтэй ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээ:**

Бүртгэл, мэдээллийн санд 1644 ажил хайгч иргэн бүртгэлтэй байна. Үүнээс эмэгтэй 761. Ажил хайж буй иргэдий боловсролын түвшингээр авч үзвэл хамгийн их 55,6 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 16,3 хувийг тусгай, техникийн боловсролтой иргэд, 16,2 хувийг дээд боловсролтой иргэд, 0,05 хувийг суурь боловсролтой иргэд эзэлж байна.

### **Шинэ ажлын байр:**

Ажил олгогч аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс 151 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлсний дагуу “Дорнод ажлын байр” хуудас болон хэвлэмэл хуудсаар иргэдэд санал болгож 173 иргэнийг ажлын байранд зуучилсан. Ажилд зуучлагдсан иргэдээс 113 иргэн шинэ ажлын байраар хангагдаж 36 иргэн улирлын, 63 иргэн түр ажлын байраар тус тус хангагдсан байна.

### **Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах ажлын хүрээнд:**

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж буй 4 аж ахуй нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан 2020 оны 09 дүгээр сард нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж 6 иргэнийг байнгын ажлын байраар хангаад байна.

### **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:**

#### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр:**

Ажил олоход хүндрэлтэй зорилтот бүлгийн 1 иргэнийг “Бид гялс” ББСБ ХХК-д ажилд зуучлан, ажил олгогч компанитай ажил олгогчийн урамшуулал олгох гэрээ байгуулав.

#### **Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр:**

Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмадуудын мэдээллийн сан үүсгэсэн. Ахмадын мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох зорилготой санхүүгийн чиглэлээр 1 ахмад мэргэжилтний хүсэлтийг хүлээн авч, 588,0 мянган төгрөгний санхүүжилт олгосон.

#### **Албан бус салбарт хөдөлмөр эрхлэлтийн талаар:**

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн суурь судалгааны ажлыг МУИС-ийн Социологийн боловсролын төвөөр гүйцэтгүүлээд байна.

Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн Орон нутгийн санаачлагын төслийн хүрээнд хийгдсэн уг судалгааны ажлын тайлант, хэлэлцүүлгийг 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж, 14 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нар, хөдөлмөр халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөлд судалгааны дүнг танилцуулсан.

Төслийн үр дүнд албан бус салбарт хөдөлмөр эрхэлж буй иргэдийн төлөв, хөдөлмөрийн харилцаа, ажлын байрны нөхцөл, эрхэлж буй үйл ажиллагааны ирээдүйн зорилгыг тодорхойлж судалгааны нэгдсэн санг бүрдүүлээд бөгөөд энэ нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 2.6.5-т заасан Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээлэл сайжирсан байна гэсэн зорилтыг хэрэгжүүлж байгаа бөгөөд мэдээллийн санд үндэслэн албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэгчдийг дэмжиж орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тодорхойлох ач холбогдолтой юм.

#### **Нийгмийн халамжийн чиглэлээр:**

Нийгмийн халамжийн тэтгэвэр 1752 иргэн хамрагдаж, 494,9 сая төгрөг, асаргааны тэтгэмжид 1344 иргэнд 121 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 256 иргэнд 72,5 сая төгрөг, эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмжид 5172 иргэнд 351 сая төгрөг, ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлтөд 2438 иргэнд 257,5 сая төгрөг, алдар цолтой ахмад настны нэмэгдэл, хөнгөлөлтийг 31 ахмад настанд 4,8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтийг 288 иргэнд 16,6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

#### **Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, хүүхдийн мөнгөний талаар:**

Тухайн сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 14 сумын 2339 өрхийн 6935 том хүн, 6038 хүүхдэд нийт 12973 хүнд хүргэж, 321,968.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээтэй холбоотойгоор тус сард 74 өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны асуулгыг мэдээллийн санд оруулж, зөрчилгүй 43 өрхийн оноог бодуулсан.

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаж, тулгалтаар мэдээлэл зөрүүтэй гарсан 126 өрх аймгийн хэмжээнд байна. Үүнээс Хэрлэн сумын 40 өрхтэй утсаар холбогдож, мэдээллийн зөрүүг завсарлуулах талаар мэдээлэл өгсөн.

Мэдээллийн зөрүүг холбогдох баримтаар баталгаажуулан 32 өрхийн оноог бодуулахаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн.

Өрхийн нэгдсэн мэдээллийн санд 2020 оны 09 дүгээр сард 205 өргөдөл гомдол бүртгэгдсэн байна. Үүнээс цахилгааны хөнгөлөлт 4, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцаа хүссэн иргэн 11, Иргэний эрүүл мэнд даатгалын үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөгдөх 28, хүүхдийн мөнгөн тэтгэмж 99 бусад байдлаар 4 өргөдөл гомдол гаргасан байна. Тус өргөдлийн 78 хувийг шийдвэрлэсэн.

### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглэлээр:**

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс” энэ сард 2 удаа хуралдаж, 13 хүүхдийн асуудлыг хэлэлцэн 4 хүүхдийн байнгын асаргааг шинээр тогтоож, 1 хүүхдийн байнгын асаргааг цуцалж, 6 хүүхдийн байнгын асаргааг сунгав. Мөн 11 хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд, 12 хүүхдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучлаад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвд давхардсан тоогоор хөгжлийн бэрхшээлтэй 80 орчим хүүхдийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбоо” төрийн бус байгууллагын Дорнод аймаг дахь салбартай хамтран аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Биеийн тамирын арга зүйч багш 7 хоногийн 2 өдөр нийт 50 цагийн спортын арга хэмжээг зохион байгуулж, саа саажилттай хүүхдүүдэд дасгал хөдөлгөөн зааж хөгжүүлэн ажиллаж байна.

Мөн спорт зааланд хуваарийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дасгал хөдөлгөөн, спортын төрлийн тенхик зэргийг зааж хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байна. Үүнд Хэрлэн сумын 11 багийн давхардсан тоогоор 180-аад иргэн хамрагдаад байна.

“Lead Mongolia” хөтөлбөрийн 30 залуусын санаачлагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэх, нийгмийн идэвхи оролцоог хангах зорилгоор 25 хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч нартай хамтарсан 4 төрөлт спортын арга хэмжээ зохион байгуулсан.

“Олон Улсын Дохионы хэлний өдөр”-ийг тохиолдуулан 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр хэл ярианы болон сонсголын бэрхшээлтэй өсвөр үе, залуучуудыг нэгтгэн гэр бүл, найз нөхдөөрөө хамтдаа суралцах, төрөөс үзүүлж буй үйлчилгээний талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хэл ярианы болон сонсголын бэрхшээлтэй 25 залуучуудын дунд “Сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг баталгаажуулах нь” сэдвийн хүрээнд спортын өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.

### **Ахмад настны асуудлаар:**

Ахмад настны тухай хуулийн дагуу жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрийг тохиолдуулан аж ахуйн нэгж, байгууллага бүр ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулж, “Ахмадын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлж ирсэн. Энэ жил аймгийн Засаг даргын 2020 оны А/483 дугаар захирамжаар аймгийн нийт ахмад настныг мэдлэг, туршлагаа хойч үедээ өвлүүлэх, нийгмийн дунд эрүүл, идэвхтэй амьдрах, хөгжих боломжийг хангах, ажиллаж байсан байгууллага нь татан буугдсанаас, харьяалалгүй байгаа ахмадуудыг, өөрийн аж ахуй нэгжид бүртгэлжүүлэх уриалга гаргасан. Уриалгын хүрээнд “Ахмадын ачлал” /2017-2020/ хөтөлбөрийн тайланг сонсох, ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж, шагнаж урамшуулах, ахмад настнуудын санаа бодлыг сонсох, тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг судлан шийдвэрлэх уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах, “Ахмадын ачлал” /2017-2020/ хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар санал асуулга авах, албан байгууллагад харьяалалгүй ахмадуудыг бүртгэлжүүлэх арга хэмжээ зохион байгуулж байна.

### **Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ:**

Сэргээн засах үйлчилгээгээр өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаварыг арилган амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн тусламж үйлчилгээг “Дойт баян бүрд” ХХК-ийн дэргэдэх мэдрэл сэргээн засах эмнэлэг нь сэргээн засах үйлчилгээг 10 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

Ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор ахмад настанд зориулсан зөвлөгөө өгөх үйлчилгээ, өдрийн үйлчилгээг хөдөө орон нутгийн болон алслагдсан баг, хороонд амьдарч буй ахмадуудад хүргэх зорилготойгоор ахмадын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий “Ашид батжих” ТББ, “Монголын хөдөөг шинэчлэхийн төлөөх фермерүүдийн холбоо” ТББ, ахмадын хороо түүний тэргүүлэгчидтэй хамтран Баянтүмэн, Хэрлэн сумын 8 дугаар багийн ахмадуудад хүрч очиж үйлчилгээ үзүүлсэн. Нийт 40 ахмад настанд зөвлөгөө өгөх үйлчилгээ, өдрийн үйлчилгээ үзүүлж, 1,440.0 мянган төгрөг зарцуулсан.

### **“Цахим монгол” хөтөлбөр:**

Ehalamj.mn цахим систем шинээр нэвтэрч байгаатай холбогдуулан иргэдийн дансыг системд холбох зорилгоор аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын зөвлөн туслах мэргэжилтнүүд арилжааны банкны салбарууд болон хүн олноор цуглардаг зах дээр байрлаж ажиллав.

**Зургаа. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг**  
**Эрүүл мэндийн газар:**

Аймгийн Засаг даргын 2020 оны А/02 дугаарын захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор алслагдсан хөдөөгийн хүн амд төрөлжсөн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээ үзүүлэх “Явуулын эмнэлэг”-ийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тусламж үйлчилгээнд “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмын хүрээнд алслагдсан бүс нутгийн иргэд, хилийн цэргийн анги, заставын албан хаагчдын гэр бүл, үр хүүхдүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ойртуулах, намаржилт болон шинэ коронавируст халдварын үед гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх ажилд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр зохион байгуулав. Үзлэгт алслагдсан 13 сумын 10183 иргэнийг хамруулсан ба үзлэгээр 87,31 хувьд нь өвчлөл илэрсэн. Үүнээс шинэ өвчлөл 16,8 хувийг эзлэж байна. Алслагдсан нутгийн иргэдийн 28,69 хувийг хамруулсан.

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 13 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 24 нийт 37 байгууллагад хоол үйлдвэрлэл үйлчилгээ, коронавируст халдвар болон томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дэмжлэгт хяналт үнэлгээг 2020 оны 09 дүгээр сарын 11-14-ний хугацаанд зохион байгуулж ажлын байран дээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Дэмжлэгт хяналт үнэлгээнээс гарсан зөвлөмж, саналыг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл, урлагийн газарт хүргүүлсэн.

Коронавируст халдвар (Covid 19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүл мэндийн яам, Нийгэмийн эрүүл мэндийн үндэсний төв, НҮБ-ын Хүүхдийн сангаас санаачилсан “Эрүүл ахуйн аян” аймгийн хэмжээнд 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 9 дүгээр сарын 01-ний хооронд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран 4 чиглэлээр зохион байгуулсан.

Аяны хүрээнд Хэрлэн сумын сууц өмчлөгчдийн нийт 16 холбоонд орон сууцны орчимд халдвар хамгааллын эрсдэлтэй цэгүүдэд цэвэрлэгээ, ариутгал хийх зөвлөгөө өгч, орон сууцны байруудын гадна орчны болон орцны цэвэрлэгээ, хүүхдийн тоглоомын талбай, подваль, зоорийг угааж, цэвэрлэн, халдваргүйжүүлэлт хийсэн. Орон нутгийн “Дорнод”, “ТВ-6”, “Нутаг 21” телевизүүдтэй гэрээ байгуулан, 9-11 дүгээр саруудад хуваарийн дагуу анимэйшн, шторк, “Түмэн гэр бүл”-ийн зөвлөмжийг нэвтрүүлэн, олон нийтийн сүлжээнд байршуулан түгээж байна.

“Хүн амын эрүү нүүрний гажиг, нойрны эмгэгийн тархалт хамаарал” сэдвээр АШУҮИСургуулийн 16 багш, судлаачид Хэрлэн сумын 118 иргэдэд шүд, сэтгэц, эмэгтэйчүүд, мэдрэл, дотор, чих хамар хоолойн үзлэг болон эмнэлзүйн судалгаа авч хамтран ажилласан.

Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Боловсролын байгууллагын багш, ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах ажлын удирдамж”-ийн дагуу эхний ээлжинд 18-34 насны багш нарыг оруулж, хамрагдалт 98 хувьтай байна.

Глобаль сангийн дэмжлэгтэйгээр Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооноос Дорнод аймгийн 5 сумын 7 уурхайн ажилчдын дунд сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх үзлэг шинжилгээг 2020 оны 8 дугаар сарын 28-аас 10 дугаар сарын 03-ны хооронд зохион байгуулсан. Илрүүлэг үзлэгт нийт 619 ажилчдыг хамруулж, сүрьеэгийн 1 тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан.

Аймгийн засаг даргын 2020 оны А/05 дугаар захирамжийн дагуу “Халдварт сүрьеэ өвчлөлийг бууруулах” төсөл арга хэмжээний хүрээнд 13 сумын зорилтот бүлгийн 2900 иргэнийг сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулж, сүрьеэгийн 2 тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан.

Аймгийн засаг даргын 2020 оны А/24 дүгээр захирамжийн дагуу “Бэлгийн замаар дамжих халдварын өвчлөлийг бууруулах” ажлын хүрээнд Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хосолсон тест, урвалж бодис, тэжээл зөөдөг сав, пипетка зэрэг 11 нэр төрлийн оношлуурыг тараасан.

Бага насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хашаандаа тээврийн хэрэгслийг байрлуулах, хөдөлгөөн эхлэх үед сонор сэрэмжийг дээшлүүлэх, эцэг эхийн хараа хяналтыг сайжруулах зорилгоор “Бид аюулгүй тогломоор байна” аяныг аймгийн хэмжээнд 2020 оны 7 дугаар сарын 20-ээс 9 дүгээр сарын 20-ны хооронд аж ахуй нэгж, байгууллагуудыг хамруулан зохион байгуулсан. Аянд идэвхи санаачлагатай оролцсон 10 байгууллагуудад урамшуулал олгож, талархал гардуулсан.

Томуугийн сайн дурын дархлаажуулалтад 480 иргэн хамрагдагдаад байна. Эрүүл мэндийн яамнаас хуваарилагдсан Тамифлю эмийг Эрүүл мэндийн байгууллагуудад түгээж байна.

“Эх хүүхэд нөхөн үржихүйн” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж, хүүхдэд үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх, шинэ залуу эмч нарын ур чадварыг сайжруулах зорилгоор “Хүүхдийн өвчний цогц менежмент”-ийн чиглэлээр 3 өдрийн сургалтыг зохион байгуулж, 50 эмч, мэргэжилтэнг хамруулсан.

### **Зургаа. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР**

#### **Мал аж ахуй:**

**Аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээл бэлтгэл:** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020-2021 оны өвөлжилт, 2021 оны хаваржилтын бэлтгэл хангах, байгалийн эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулах 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж, аймгийн хэмжээнд 2020 оны жилийн эцэст 5311 малчин өрхөд 2,629,622 толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 5,4 сая толгой мал өвөлжихөөр бэлтгэл хангаж байна.

2020-2021 оны Өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор малчдын түвшинд өвс 89928,0 тн бэлтгэхээс 43688 тн буюу 48.5 хувь, тэжээл 360 тн бэлтгэхээс 70.0 тн буюу 19.4 хувь бэлтгэж, дунджаар 33.9 хувьтай, аймгийн аюулгүй нөөцийн өвс 700 тн бэлтгэхээс 172,6 тн өвс бэлтгэж 24,6 хувь, 150 тн тэжээл бэлтгэхээс 34,3 тн тэжээл буюу 22,8 хувь, нийт 23,8 хувьтай, сумын аюулгүйн нөөц 1400 тн өвс бэлтгэхээс 499,9 тн өвс бэлтгэж 35,7 хувь, 560 тн тэжээл бэлтгэхээс 218,5 тн тэжээл бэлтгэж 39 хувьтай бэлтгэл хангаж байна.

Аймгийн хэмжээнд хадлан, тэжээл бэлтгэлийн ажил дунджаар **37,3** хувьтай явагдаж байна. Аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээл, малчдын түвшинд бэлтгэсэн өвс, тэжээлийн мэдээг долоо хоног бүрийн Пүрэв гарагт ХХААХҮЯаманд хүргүүлэн ажиллаж байна.

**Хадлангийн газрын талаар:** Аймгийн хэмжээнд 12 сумын 113,3 мянга га газар хадлан бэлтгэхээр сумын ИТХ-ын тогтоолоор баталсан. Аймгийн ИТХ-аар баталсан “Бэлчээр, хадлан, тэжээлийн талаар баримтлах бодлого”-ын 5.2.11 дэх заалтын хүрээнд Баяндун, Баянтүмэн, Баян-Уул, Хөлөнбуйр, Матад, Халхгол, Чойбалсан сумдууд үйлдвэрлэлийн зориулалтаар хадлангийн газрын зөвшилцөх хүсэлтийг

шийдвэрлэсэн. Сумдууд үйлдвэрлэлийн зориулалттай хадлангийн газрыг иргэн, аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

№	Сумдын нэр	2020 онд төлөвлөгдсөн хадлангийн хэмжээ /га/	Гэрээгээр байгуулсан иргэн ААНБ, газрын хэмжээ		Үүнээс Өөр аймаг сумаас		Техникийн тоо					Ажиллах хүчний тоо	Төлөвлөгөө батлагдсан тогтоолын огноо, дугаар
			Сүлжээ	ын хадлангийн	ААНБ-ын хадлангийн	Трактор	Хадуур	Тармуур	Төмөр замын боогч	Циргүүл			
1	Баяндун	9350	18	9650	4	3000	62	44	21	16	22	130	2019.12.12 №06
2	Баян-Уул	300	3	300	0	0	8	5	3	2	3	16	2019.12.19 №08
3	Баянтүмэн	4500	30	3550	0	0	81	74	28	28	28	188	2019.12.16 №13
4	Булган	2800	16	2800	0	0	32	40	31	17	15	138	2019.12.18 №04
5	Гурванзагал	1000	2	800	0	0	4	5	2	1	15	13	2019.10.30 №73
6	Дашбалбар	6700	1	1000	0	0	5	3	1	1	6	12	2020.07.10 №01
7	Матад	16000	16	11500	0	0	14	14	13	4	24	34	2019.11.29 №20
8	Сэргэлэн	3000	16	1348	0	0	23	17	13	6	24	57	2020.08.10 №01
9	Халхгол	29000	18	12300	3	2500	56	33	22	20	16	111	2020.08.07 №01

10	Хөлөнбуйр	3000	46	8000	12	2200	107	82	60	43	29	339	2019.12.12 №04
11	Цагаан-Овоо	-											-
12	Чойбалсан	16000	22	8850	2	600	38	32	24	13	19	83	2019.12.19 №06
13	Чулуунхорoot	21665.6	1	500	1	500							2019.12.20 №03
<b>Нийт</b>		<b>113315.6</b>	<b>189</b>	<b>60598</b>	<b>22</b>	<b>8800</b>	<b>430</b>	<b>349</b>	<b>218</b>	<b>151</b>	<b>201</b>	<b>1121</b>	-

Аймгийн хэмжээнд 12 сумын хэмжээнд нийт 189 хадлангийн салаа 60598 га газарт хадлан бэлтгэж байна. **Үүнээс:** Улаанбаатар 10 хадлангийн салаа 5100 га газарт, Төв аймгийн 4 хадлангийн салаа 2100 га газарт, Хэнтий аймгийн 5 хадлангийн салаа 850 га газар, Сүхбаатар аймгийн 1 хадлангийн салаа 250 га газарт, Багануур дүүргийн 1 хадлангийн салаа 200 га газарт, Сэлэнгэ аймгийн 1 хадлангийн салаа 300 га газарт, **нийт 22** хадлангийн салаа 8800 га газарт өөр аймаг, сумаас хадлан бэлтгэж байна.

**Хадланд ажиллах техникийн бэлэн байдал:** Аймгийн хэмжээнд хадлан бэлтгэлийн ажилд трактор 174 ширхэг, бага оврын трактор 777 ширхэг, хадуур 746 ширхэг, тармуур 617 ширхэг, хаман боогч 116 ширхэг, нуруулдагч 44 ширхэг, морин хадуур 188 ширхэг, морин тармуур 100 ширхэг, тракторын чиргүүл 387 ширхэг урьдчилсан байдлаар ажилд бэлэн байгаагаас трактор 430 ширхэг, хадуур 349 ширхэг, тармуур 218 ширхэг, хаман боогч 151 ширхэг, чиргүүл 201 ширхэг, хүн хүч 1121 хүн хадлан бэлтгэлийн ажилд ажиллаж байна.

**Өвсний гарал үүслийн гэрчилгээ:** 2020 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 580 ширхэг өвсний гарал үүслийн гэрчилгээг гаргаснаас Баяндун сум 90 ширхэг, Булган сум 100 ширхэг, Гурванзагал сум 10 ширхэг, Матад сум 40 ширхэг, Халхгол сум 100 ширхэг, Хөлөнбуйр сум 200 ширхэг, Баянтүмэн сум 20 ширхэг, Дашбалбар 40 ширхэг, Хэрлэн 20 ширхэг авч иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад өгсөн байна.

**Өвс, тэжээлийн агуулах саравч хүлээн авлаа:** Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт төсөл, орон нутгийн хөгжлийн сангийн 330,0 сая төгрөгийн хөрөнгөөр Сэргэлэн, Хэрлэн сумдад “Өвс, тэжээлийн агуулах саравч шинээр барих” ажлыг “Смарт лифт” ХХК, Халхгол суманд “Ар өвөр эрээн” ХХК тус тус зураг төсвийн дагуу 100 хувь гүйцэтгэж аймгийн Засаг даргын А/433 дугаар захирамжаар байгуулагдсан Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга н.Гүенбатаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг, сумын Засаг дарга, холбогдох ажилтнуудын хамт тус сумдад баригдсан өвсний саравч, тэжээлийн агуулахыг 100 хувийн саналаар хүлээн авч ажиллаа.

1. Халхгол сум өвсний саравч, тэжээлийн агуулах / гүйцэтгэгч: “Ар өвөр эрээн” ХХК/
2. Сэргэлэн сум-“Өвсний саравч, тэжээлийн агуулах” /гүйцэтгэгч: ”Смарт лифт” ХХК/
3. Хэрлэн сум-“Өвсний саравч, тэжээлийн агуулах” / гүйцэтгэгч: ”Смарт лифт” ХХК/

**Бэлчээрийн усан хангамж:** Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 онд “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт” төслийн 506,0 сая төгрөгийн санхүүжилтээр 22 инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн гүйцэтгэлийг “Сатабу” ХХК гүйцэтгэхээс 17 худаг буюу 77,2 хувь, Байгаль хамгаалах сангийн 170,0 сая төгрөгийн хөрөнгөөр 17 цооногийн гүйцэтгэлийг “Сатабу” ХХК гүйцэтгэхээс 6 цооног буюу 35,2 хувь, Орон нутгийн хөгжлийн сангийн 130,0 сая төгрөгийн хөрөнгөөр 13 цооногийн гүйцэтгэлийг “Дөлгөөн Хэрлэн” ХХК гүйцэтгэхээс 9 цооног буюу 69,2 хувьтай тус тус гүйцэтгээд байна. Аймгийн хэмжээнд 17 гүн өрмийн худаг, 15 цооногийг хүлээж аваад байна.

Энэхүү ажлыг зохион байгуулснаараа 168 малчин өрхийн 84000 толгой малыг усаар хангах боломж бүрдэж, нийт бэлчээрийн газрын 1,2 хувийг усаар хангах юм.

**Бог мал угааврын ванн хүлээж авах ажиллаар Халхгол суманд ажиллаа:**

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт төсөл”, орон нутгийн хөгжлийн сангийн 120,0 сая төгрөгийн хөрөнгөөр Сэргэлэн, Гурванзагал, Дашбалбар сумдад “Бог мал угааврын банн” барих ажлыг “Смарт лифт” ХХК, Баянтүмэн, Халхгол, Хөлөнбуйр, Цагаан-Овоо сумдад “Жорон” ХХК тус тус гүйцэтгэгчээр шалгарсан.

Аймгийн Засаг даргын А/408 дугаар захирамжаар байгуулагдсан Мал эмнэлэгийн газрын дарга Ч.Аюушмаагаар ахлуулсан 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг “Смарт лифт” ХХК-ны Сэргэлэн, Гурванзагал, Дашбалбар сумдад хийгдсэн 3 “Бог мал угааврын банн”-ыг хүлээж авсан.

“Жорон” ХХК-ны Халхгол суманд гүйцэтгэсэн “Бог мал угааврын ванн”-ыг хүлээж авахаар 2020 оны 09 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд ажлын хэсэг ажиллахад Ялалт, Ташгайт багт баригдсан бог мал угааврын ванны булан хагарсан, гарах зогсоолын гагнаас салсан, будаг нэмэх зэрэг ажлууд хийх шаардлагатай тул гүйцээж, зөрчилийг арилгасан тохиолдолд ажлын хэсэг хүлээж авахаар үүрэг чиглэл өгөн ажиллалаа.

**Аймаг дундын отрын нөөц бэлчээр:** Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ханган ажлын хүрээнд Чойбалсан сумын нутаг дэвсгэрт орших аймаг дундын отрын нөөц бэлчээрт Баянтүмэн, Гурванзагал, Сэргэлэн, Чулуунхороот сумдаас адуу 21706 толгой, тэмээ 1113 толгой, үхэр 13319 толгой, хонь 68316 толгой, ямаа 44329 толгой нийт 148783 толгой мал отроор оруулах санал ирээд байна. Саналыг аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанд хүргүүлэн ажиллаж байна.

Улсын тусгай хамгаалалттай газар 412 өрхийн 244973 толгой мал, Орон нутгийн тусгай хэрэгцээний газарт 278 өрхийн 196434 толгой мал, Хилийн зурвас газарт 146 өрхийн 52887 толгой мал отроор өвөлжих мэдээтэй байна



- ❖ Дашбалбар сумын 12 малчин өрхийн буриад омгийн 238 толгой хуц , 749 толгой эм хонь, нийт 987 толгой Буриад омгийн хонь,
- ❖ Хөлөнбуйр сумын 2 малчин өрхийн барга үүлдрийн 231 толгой хуц, 235 толгой эм хонь, нийт 506 толгой Барга үүлдрийн хонь,
- ❖ Цагаан-Овоо сумын 11 малчин өрхийн нутгийн хар ухна 53 толгой, 68 толгой эм ямаа , нийт 121 толгой нутгийн хар ямааны ээмэгжүүлсэн судалгааг Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программд оруулсан.

**Малын ээмэгний захиалга авч ажиллаа:** Малын генетик нөөцийн тухай хууль, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Баянтүмэн сумын 1 малчин өрхөд 200 толгой үхрийн ээмэг, Баяндун сумын 1 малчин өрхөд 90 толгой үхрийн ээмэг нийт 2 сумын 2 малчин өрхийн 290 толгой малын ээмэгний захиалгыг ХХААХҮЯам болон “Тэргүүн сүрэг” ХХК-иудад захиалгыг хүргүүлж ажилласан. Малчид малаа ээмэгжүүлж, бүртгэлжүүлсэн тайлангаа 10 дугаар сарын 15-ны дотор ирүүлж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программд оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

**Үүнд:** Баянтүмэн сумын Жаргалант 2-р багийн малчин Онон овогтой Батбилэг 200 үхрийн ээмэг, Баяндун сумын Яргай 3-р багийн малчин Цэдэв овогтой Ганбаатар 90 толгой үхрийн ээмэгний захиалгыг сум, багаар гаргаж хүргүүлж ажилласан.

**“Ноолуур бэлтгэх, ангилах ялгах” сургалтанд хамрагдсан тухай:** Тогтвортой ноос ноолуур эвсэл, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын нэмэлт санхүүжилт төсөл, Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ мэдээлэл арга зүйн төвөөс хамтран “Ноолуур бэлтгэх, ангилах ялгах” сургалтыг 2020 оны 09 сарын 7,8-ны өдрүүдэд Төв аймгийн Эрдэнэ сумын Мэргэжил сургалт үйлдвэрийн төвд зохион байгуулагдаж, 6 аймгийн 20 МСҮТ-ийн багш нар ,Орон нутгийн ХАА-н мэргэжилтнүүд хамрагдсан.

Тус сургалтыг ноолуурын салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан мэргэжилтэнүүд болон мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээний чадварлаг арга зүйч багш нар удирдан явуулсан бөгөөд ноолуурыг тогтвортойгоор хуралдаанд бэлтгэх үндэс суурь болох ноолуур самнах ажлын бэлтгэл, шаардагдах зохистой арга

ажиллагаа, ноолуурыг өнгө, насаар нь ангилан ялгах сургалтын арга зүйн онцлог, хөтөлбөр боловсруулах аргачлалын талаар мэдээлэл өгсөн.

Энэхүү сургалтаар ямаа самнах үеийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ноолуурын өнгө чанарын зэрэглэл, ноолуурын шинж чанар, бүтэц, ноолуурыг уутлах, анхаарах зүйлс, хадгалах орчин зэрэг хичээлүүдийг танимаар, дадлага ажил малчны суурьт очиж дадлага хийсэж “Ханбогд кашимер” үйлдвэрийн үйл ажиллагаа, анхан шат болон гүн боловсруулах үе шаттай танилцсан.

Сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан МСҮТ-ийн багш нар ,Орон нутгийн ХАА-н мэргэжилтнүүд цаашид малчин эмэгтэйчүүдэд ноолуурыг чанарын шаардлагын дагуу худалдаанд зохистой бэлтгэх талаархи мэдлэг, ойлголтыг олгох чадамжид суурилсан сургалтанд хамрагдаж, гэрчилгээ гардан авлаа.

**Дорнод аймгийн “Албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэлт-2020” судалгааны тайлан, хэлэлцүүлэгт оролцлоо:** Дорнод аймгийн хүн амын албан бус хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдлыг судалж, мэдээллийн сан бүрдүүлэх тайлан, санал дүгнэлт гаргах зорилгоор “Дорнод аймгийн “Албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэлт-2020” судалгааны тайлан, хэлэлцүүлгийг 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр аймгийн ЗДТГ-ын хурлын зааланд аймгийн ХХҮГазар зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт холбогдох агентлаг болон сумдын ЗДТГазрын дарга, мэргэжилтнүүд 30 гаруй хүн оролцож МУИС-ийн социологийн Боловсрол төвийн захирал, дэд профессор М.Батбаатар Дорнод аймгийн албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгаа үр дүнгийн танилцуулга хийж, санал бодлоо солилцлоо.

Цаашид албан бус салбарт хөдөлмөр эрхэлж буй иргэдийн судалгааг гаргаж мэдээллийн сан үүсгэх, Хил дамнан хөдөлмөр эрхлэх асуудлаар бүс нутгийн хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулах, албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэгч иргэдийг төрөөс үе шаттайгаар дэмжин албан салбарт шилжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаатай уялдуулан албан бус салбар дахь эрэлтийг тооцох, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийг албан салбарт шилжүүлэх талаар нөлөөллийн ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллахаар шийдвэрлэсэн.

## ГАЗАР ТАРИАЛАН:

Энэ онд аймгийн хэмжээнд ХХААХҮЯамны сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүний нийлүүлэх гэрээгээр 22,6 мянган га-д үр тариа, үүнээс 18,5 мянган га-д улаан буудай, 4,5 мянган га-д тосны ургамал, 2,5 мянган га-д малын тэжээл 161 га-д төмс, 117 га-д хүнсний ногоо тариалж, үр тарианы ургац 27,0 мянган тн, үүнээс 22,2 мянган тн улаан буудай, 4,8 мянган тн бусад үр тариа, 3,6 мянган тн тосны ургамал, 1,9 мянган тн төмс, 1,4 мянган тн хүнсний ногооны ургац хураан авахаар төлөвлөөд байна .

Энэ онд нийт 93,2 мянган га эргэлтийн талбайн 35,0 мянган га-д тариалалт, 35,2 мянган га-д уриншийн боловсруулалт хийхээр төлөвлөж 70,2 мянган га буюу 75,4% эргэлтэд оруулаад байна.

Нийт эргэлтийн талбай (га-аар)	Тариалсан талбай (га-аар)	Боловсруулах уриншийн захиалга (га-аар)	Эргэлтэнд орох талбай (га-аар)	Талбайн Ашиглалт ( хувиар)
93266	35083	35280	70363	75.4

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 07 дугаар хуралдааны 09 тогтоолоор батлагдсан Таримлыг тариалангийн талбайн сэлгээнд тариалах тухай тогтоолын хүрээнд нийт тариалсан талбайн 80,2% үр тариа, үүний 61% улаан буудай, 5,6% тосны ургамал, 13,4% малын тэжээл, 0,8% төмс, хүнсний ногоо тус тус эзэлж байна.

ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 08 сарын 10 өдрийн 01/2739 албан тоотоор өгсөн чиг үүргийн хүрээнд 2020 онд хураан авах ургацын урьдчилсан төлөв байдлыг тариалангийн бүс нутагт ажиллаж улаан буудай 21411 га-аас 1000 га тэжээлд шилжиж 20411 га-аас 14,6 цн буюу 29800 тн ургац, төмс 179,9 га-аас 112,5 цн буюу 2023,8 тн, хүнсний ногоо 120,5 га-аас 95 цн буюу 114,7 тн, малын тэжээл 5718 га-аас 6461 тн ургац хураан авах төлөвлөгөөг гаргасан.

2020 оны 09 сарын 25 өдрийн байдлаар улаан буудай 5.6 мянган га-аас 7.3 мянган тн, малын тэжээл 768 га-аас 725 тн, төмс 84.4 га-аас 747.3 тн, хүнсний ногоо 58.6 га-аас 390.4 тн хураан авч, урагц хураалт 16.5%-тай явж байна.

Дотоодын гурилын үйлдвэрт 3 сумын 6 аж ахуй нэгж 2539.1 тн товарын улаан буудай нийлүүлээд байна. Ургац хураалт 18.7 хувьтай явагдаж байна.

**ДОРНОД АЙМГИЙН 2020 ОНЫ УРГАЦ ХУРААЛТЫН МЭДЭЭ**

Дэс дугаар	Таримлын төрөл	Тариалсан талбай/га-аар/	ургац өлдсөн талбай /га-аар/	Тэжээлд шилжсэн	Хураах талбай /га-аар/	Ургац хураалт				Буудайн хуваарилалт				
						Хураасан талбай /га-аар/	гэгжийн ургац /цн-ээр	Хураан авсан ургац /тн-оор/	хураалтын	Дорнод гурил	ХХК	Хуурайгууц	гурил тусгай	тушаасан/ тн/ гүмэг шуруут
1	Улаан буудай	21411	50	1000	20361	5600	13.1	7317	27.5	2539				
2	Бусад үр тариа	6666	0	200	6466				0.0					
3	Тосны ургамал /га-аар/	1968	200	0	1768				0.0					
4	Малын тэжээл /га-аар/	4718	0	1200	5918	768	9.4	725	13.0					
5	Төмс /га-аар/	179.895			179.9	84.436	88.5	747.3	46.9					
6	Хүнсний ногоо /га-аар/	120.5			120.5	58.63	66.6	390.4	48.7					
<b>7</b>	<b>Нийт дүн</b>	<b>35063</b>	<b>250</b>	<b>2400</b>	<b>34813.4</b>	<b>6511.1</b>		<b>9180</b>	<b>18.7</b>	<b>2539.10</b>				

**ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, ахуйн үйлчилгээ, зээлийн батлан даалтын сан: Монгол улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн

113 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу нийт 33 төслийг хүлээн авч бүртгэсэн.

Эхний шатанд журмын 1.4 дүгээр заалтаар 2 төсөл, 5.9 дүгээр заалтаар 10 аж ахуйн нэгжийн төсөл хасагдаж нарийвчилсан шат руу 21 төслийг шилжүүлсэн.

Гурав дахь шат нарийвчилсан шатанд тухайн төсөл хэрхэн хэрэгжих боломжтой эсэх, өөрөөс санхүүжих хөрөнгө нь баталгаажиж байгаа эсэх, төслөө бэлэн болгоход ямар зардал хөрөнгө гаргасан зэргийг ЖДҮХСангийн мэргэжилтэн Н.Номин, Б.Энхцэцэг нар Хэрлэн, Дашбалбар, Булган сумдад ажиллаж, 11 аж ахуйн нэгж 70-аас дээш оноогоор дүгнэгдсэн.

Дэд хорооны хурал 09 дүгээр сарын 10-ны өдөр 100% ирцтэйгээр хуралдаж, 11 төсөлд оноо өгч эрэмбэлсэн.

Аймгийн Засаг даргын 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/466 дугаар захирамжаар дэд хорооноос гарсан тогтоолыг баталгаажуулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлээд байна.

**Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны сургалт, мэдээлэл хийлээ:** Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны талаар 09 дүгээр сарын 03-нд 19 иргэн, аж ахуйн нэгжид, 09 дүгээр сарын 23-нд Хаан банкны 12 харилцаан менежерүүдэд тус тус сургалт, мэдээлэл өгч ажилласан.

**Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон тоног төхөөрөмжийн судалгаа:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргатай байгуулсан гэрээний 52 дугаар заалтад “сум хөгжүүлэх сангийн хөрөнгөд 2014 онд ахуйн үйлчилгээний зориулалтаар олгосон ашиглагдахгүй байгаа тоног төхөөрөмжийг сумын эргэлтийн сангийн хөрөнгөнд бүртгэж, дахин үнэлгээ хийж, зах зээлийн үнээр худалдан борлуулах, авлага барагдуулах ажлыг зохион байгуулах”

гэж заасныг зохион байгуулахаар сумдад үлдэгдэлтэй байгаа тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, Орон нутгийн өмчийн газарт хүсэлтээ хүргүүлээд байна.

**“Түншлэлийн хүрээнд жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийг дэмжих нь -2021” форумд оролцлоо:** Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд авлигын хор аюулыг олон нийт, төрийн албан хаагч нарт тайлбарлан таниулах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэс болон “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран 2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлын танхимд хүний нөөц, дотоод ажил хариуцсан албан хаагчдын дунд зохион байгуулсан “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” цахим сургалтад хамрагдлаа.

Тус сургалтаар АНУ-ын Олон Улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Хөгжлийн шийдэл” ТББ-ын хэрэгжүүлж буй “Best” хөтөлбөрийн танилцуулга, мэдээлэл, хөтөлбөрийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрлэл (Жижиг, дунд бизнес эрхлэгчид)-ийг эрчимтэй дэмжих, бодлогоор хөгжүүлэхэд үүсэх харилцаа, ашиг сонирхлын зөрчлөөс, төрийн албан хаагч нарыг урьдчилан сэргийлэх талаар сургалт мэдээлэл өглөө.

АНУ-ын Олон Улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Хөгжлийн шийдэл” ТББ-ын хэрэгжүүлж буй “Best” хөтөлбөрөөс зохион байгуулсан COVID-19 “Түншлэлийн хүрээнд жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийг дэмжих нь -2021” форумд оролцсон. Тус хөтөлбөрийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрлэл (Жижиг, дунд бизнес эрхлэгчид)-ийг эрчимтэй дэмжих, бодлогоор хөгжүүлэхэд талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.

### **ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:**

**Захирамжийн хэрэгжилтийг хангуулах тухай:** Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах аймгийн Засаг даргын 2020 оны А/436 захирамжийн хүрээнд сургууль, цэцэрлэгт орон нутгаас нийлүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тогтвортой явуулах арга хэмжээний урт, дунд хугацааны төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хангуулж ажиллахаар зорьж ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын төлөвлөгөөт шалгалттай хамтатган ерөнхий боловсролын сургуульд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуйн нэгжүүдээр 10 дугаар сарын 01-ээс явж үйл ажиллагаатай танилцахаар төлөвлөөд байна.

2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэлийг хангах, Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилготой “2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажил анхаарах асуудал” сэдэвт сургалтыг Боловсрол, соёл урлагийн газраас 2020 оны 8 дугаар сар 27, 28-ны өдөр зохион байгуулсан.

Үндэсний уламжлалт болон орон нутгийн онцлог бүхий хоол, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бэлтгэсэн орчин үеийн монгол хоолны видео хичээлийг аймгийн томоохон ресторонуудын дэлгэц болон телевизээр цацаж мөн байгууллагын пэйж хуудсанд байршуулж нийт 3878 хүнд түгээж ажилалаа.

### **ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

**“Намрын ногоон өдрүүд” арга хэмжээ:** Улаанбаатар хотод 09 дүгээр сарын 15-21-ний хооронд 15 дахь жилдээ зохион байгуулагдлаа. Тус үзэсгэлэн худалдаанд Дорнод аймгийг төлөөлж “Халхгол уран зөгий” ХХК, “Маш итгэл” ХХК-иуд зөгийг бал, махны дайвар бүтээгдэхүүнээр оролцож 7 өдөрт нийт 7.5 сая төгрөгний борлуулалт хийсэн.

“Маш итгэл” ХХК нь “Царцаамаг” бүтээгдэхүүнээр “Орон нутгийн хүнсний шилдэг бүтээгдэхүүн төрөлд амжилттай оролцлоо.

зэсгэлэн худалдааны үеэр ХХААХҮЯамны ХҮБХЗГ-ын дарга Л.Чой-Иш орон нутгийн мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж санал сонсож, чиглэл өгсөн. Мөн Монголын хүнсчдийн холбооноос Хүнсний аж үйлдвэрийн салбар үүсч хөгжсөн 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар мэдээлэл хийж орон нутгийн мэргэжилтнүүднээс хэрэгцээтэй байгаа дэмжлэг, мэдээллүүдийг авахаар болсон.

Дорнод аймгийн сүү үйлдвэрлэгчдийн “Дэвшил” холбооноос “Сүүний үйлдвэрлэлийн цогцолбор”-ийг Баянтүмэн суманд байгуулах санаачилгыг дэмжиж ХХААХҮСайд З.Мэндсайхан, УИХ-ын гишүүн Ц.Сэргэлэнд төслийг хүргүүлэн, Баянтүмэн суманд цогцолбор байгуулах газрын байршлын зураг, солбицлын тогтоод байна.

**“Дорнод аймгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ” хийх сургалтад хамрагдлаа:** Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтооллоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2020 оны 09 дүгээр сарын 08-09-ны өдрүүдэд Улаан загалмайн хурлын танхимд зохион байгуулсан “Дорнод аймгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ” хийх сургалтад хамрагдлаа.

Тус сургалтаар Гамшгийн эрсдэлийг үнэлэх, эрсдлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөлт, эрх зүйн шинэчлэл, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар, журамын танилцуулга болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн түвшинд эрсдэлийн ерөнхий үнэлгээг талуудын оролцоотой хийж, үнэлгээний үр дүнд суурилсан гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөнд тусгах зөвлөж боловсрууллаа.

#### **МАЛ ЭМНЭЛГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

##### **Халдварт өвчний дархлаажуулалтын талаар:**

Зооноз халдварт бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 601,0 мянган толгой төл мал хамруулахаас 591,8 мянган толгой төл мал хамруулж 98,4 хувийн гүйцэтгэлтэй дууссан.Тус сард халдварт өвчин оношлогдоогүй байна

##### **Мал угаалга:**

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 02, 05 албан даалгавар, А/76 тоот тушаал, аймгийн Засаг даргын А/193 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд мал, амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх мал угаалгын ажлыг 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж нийт 2,2 сая толгой бод, бог

малыг хамруулах төлөвлөгөөтэйгээс 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1116,0 мянган толгой мал сүргийг хамруулж 51 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

Тус арга хэмжээг зохион байгуулахад аймгийн Мал эмнэлгийн газар, сумын Мал эмнэлгийн тасаг хяналт тавьж, 43-н МЭҮН-ийн эмч нар хэрэгжилтийг ханган ажиллаж байна

#### **Тандалт шинжилгээний талаар:**

УМЭАЦТЛ-ийн захирлын 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/46 тоот тушаалын дагуу “Бруцеллёзын хээлтүүлэгчийн тандалт-2020” ажлын хүрээнд аймгийн 14 сумын 13,687 толгой хээлтүүлэгч малаас тандалтын дээж авахаас 11,969 дээжинд аймгийн МЭГ-ын МЭАЦЛ-ийн шинжлэгч эмч нар илрүүлэх шинжилгээг хийж 1 сумын 9 дээж эерэг гарч УМЭАЦТЛ-ын баталгаажуулах шинжилгээгээр 7 дээж нь эерэг гарсан дүн үзүүлсэн байна.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 1-р ээлжийн дархлаажуулалтын үйлчилгээний хөлс 287,4 сая төгрөгний санхүүжилтийг 43 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид хуваарилан олгосон.

Орон нутгийн хөгжлийн сангаас 2020 онд санхүүжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 365,9 мянган толгой мал, амьтан хамруулахаас 358,1 мянган толгой мал, амьтан хамрагдаж 97,9 хувийн гүйцэтгэлтэй дууссан. Зооноз халдварт боом, галзуу, бруцеллёз өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 1,035,276 толгой мэдрэмтгий мал хамрагдахаас 1,020,235 толгой мэдрэмтгий мал хамрагдаж 98,5 хувийн гүйцэтгэлтэй дууссан. Тус өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтэнд 237,0 сая төгрөг олгохоос 180,0 сая төгрөгийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгоод байна.

#### **Байгаль орчны чиглэлээр:**

Хоггүй цэвэр Монгол” аяны хүрээнд аймгуудын орчны бохирдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх, орон нутгийн хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг сайжруулах зорилгоор аймгийн хэмжээнд хог хаягдлыг бууруулах чиглэлээр 6 ажлыг төлөвлөн төсөв боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулж биелэлтийн хэрэгжилтийн ханган ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/106 дугаар тушаалаар манай аймагт эрх шилжүүлсэн ажлын гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу сонгон шалгаруулах ажлыг газрын даргын 2020 оны 9 дүгээр сарын 9-ны өдрийн А/13 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг зохион байгууллаа.

“Чойбалсан хотын шинээр үүсгэж буй хог хаягдлын цэг болон түүн рүү явсан замыг тэмдэгжүүлэх, мэдээллийн самбар байршуулах” ажилд “Ган эрчим хүч”ХХК, “Хогийг эх үүсвэрт ангилан ялгах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор орон сууцны орцонд ангилан ялгах зориулалтын сав худалдан авч, нийлүүлэх” ажилд “Өсөх инжир”ХХК, Чойбалсан хотын хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайн гадна орчинд үүссэн барилгын болон хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, зөөвөрлөх ажлын сонгон шалгаруулалтанд “ИГ”ХХК гүйцэтгэгчээр шалгарч, гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлээд байна.

Чойбалсан хотын хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайн гадна орчинд үүссэн барилгын болон хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, зөөвөрлөх ажлыг “ИГ”ХХК хийж гүйцэтгэж байна.

Нутаг дэвсгэртээ хамаарах улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх аймгийн Засаг даргын 2020 оны А/435 дугаар захирамжийг сумдад хүргүүлж, хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх ажил хийгдэж байна.

#### **Барилга, хот байгуулалтын ажлын чиглэлээр:**

2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга А.Гантулгаар ахлуулсан ГХБХБГ-ын дарга Д.Дамдинбазар, ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга Х.Гүенбат, Сэргэлэн сумын Засаг дарга Н.Гүррагчаа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Сэргэлэн сумын Бүдүүний булгийн хөвийн ажлын явцтай газар дээр нь очин танилцлаа.

Тус хөв цөөрөм барих ажлыг “Жишиг проект” ХХК хийж гүйцэтгэн 2018 оны 08 дугаар сарын 17-ны өдөр 1039/2018 дугаар магадлалаар оруулж баталгаажуулсан

JP2018/03 шифр бүхий зурах төслөөр “Тэнүүн Хас Сар” ХХК барилга угсралтын ажлыг 2018 оноос эхлэн хийж гүйцэтгэж байгаа ч одоогоор ажил дуусаагүй байдалтай байна.

2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр орон нутгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэж байгаа 22 аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийг хүлээн авч уулзлаа.

Тус өдөр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл арга хэмжээний ажлын явц, гүйцэтгэлийн талаар, ихэнх аж ахуйн нэгжүүдийн гаргаж буй алдаа дутагдал, анхаарах зүйлсийн талаар, барилгын материалын дээж, лабораторийн шинжилгээний талаар, хэлэлцэн заавар зөвлөгөө, анхааруулга өгч гүйцэтгэгч компанийн тулгамдаж буй асуудлын талаар санал хүсэлтийг сонсон ажиллалаа.

Матад сумын нутаг дэвсгэрт Улсын төсвийн 200 000 000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Сургуулийн хичээлийн байрын их засвар /Матад сум/”-ийн барилга угсралтын ажлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/13 дугаар шийдвэрийг үндэслэн 9 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2020 оны 09 дугаар сарын 23-ний өдрийн 15 цагт хуралдаж тухайн ажлыг гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар болов. Гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд цоколын хананд шаазан хавтан наах, гадна фасадын төмөр хавтангийн ажил болох цонхны амлагааны хэсгийг гүйцээх, бетон хаяавч цутгах /21м3/, дутуу цутгасан шаардлага хангахгүй бетон хаяавчийг задлан буулгах, хулдаасыг наах, блинтус хийх, дүүжин таазны зарим хэсгийг засварлах, дулааны насосыг суурилуулж шалган ашиглагч талд хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэн ажиллаа. Улсын комиссын актын огноо 2020-09-23 актын дугаар 90/2020

Хэрлэн сумын 6, 2 дугаар багт Улсын төсвийн 1 360 000 000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Модон гүүр болон орон сууцны 24-р байрны дэргэд шинээр хяналтын цэг байгуулах /Хэрлэн сум/” ажлыг Дорнод аймгийн Засаг даргын даргын

2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/467 дугаар захирамжийг үндэслэн 9 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2020 оны 09 сарын 21-ны өдрийн 15 цагт хуралдаж тус барилга байгууламжийг 88/2020 дугаарт акт үйлдэн барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авч ажиллаа. Тус ажил нь 3м х 5м хэмжээтэй, өвлийн дулаалгатай, төмөр карказан 2 ширхэг харуулын байрны зориулалттай тоногдсон контейнерийн барилга байгууламжийг хийж гүйцэтгэн Хэрлэн сумын Модон гүүр болон орон сууцны 24 дүгээр байрны дэргэд байршуулах ажил юм.

Аймгийн байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 2020 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад багтсан Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тохижуулах ажлыг гүйцэтгэхээр Цахим Хийц ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна.

Тус ажил нь цэцэрлэгт хүрээлэнгийн явган хүний замыг хэсэгчлэн солих болон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 1000ш мод тарих ажил хийгдэнэ. Төсвийн зөрүүтэй асуудлаас үүссэн нэгж модны үнэ болон төрлийг өөрчлөх талаар ашиглагч болон захиалагч гүйцэтгэгч нар харилцан зөвшилцөж 200ш мод тарихаар болж өөрчлөлт оруулсан. 2020 оны 9 дүгээр сарын 27-ны байдлаар явган хүний замын ажил бүрэн хийгдсэн, мод суулгах ажилбар хийгдэж 2020 оны 10 дугаар сарын 15 буюу гэрээт хугацаанд ажлыг хүлээлгэн өгөхөөр гүйцэтгэгч компани ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв Хэрлэн сум /7-р баг / ажлыг Түүх соёл ХХК гүйцэтгэж байна. Тус барилга нь зорьтой 3 давхар эмнэлгийн зориулалттай барилга байгууламж бөгөөд 2020 оны 09 дүгээр сарын 30-ний байдлаар 2 дугаар давхрын өрлөгийн ажил бүрэн хийгдсэн хучилтын хавтан тавих ажил 70%-тай явагдаж байна.

Мөн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Төрөөс орон сууц, нийтийн аж

ахуйн талаар баримтлах бодлогын хүрээнд тусгагдсан Сумын хөгжлийн стратегийн төслийг боловсруулахад шаардагдах аймаг сумдын бага оврын халаалтын зуухны мэдээлэл, төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, төсвийн байгууллагуудын дулааны тоолууржуулсан байдал, сумдад инженерийн шугам сүлжээнд холбогдох шаардлагатай барилга байгууламжийн эзлэхүүний судалгааг тус тус гарган OSNAAN@GMAIL.COM болон албан бичгээр Барилга, Хот байгуулалтын яам, Барилга хөгжлийн төвд хүргүүлэн ажиллалаа.

Хэрлэн сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ДОЦ ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 1 болон 5 дугаар сургуулийн 320 хүүхдийн хүчин чадал бүхий бага сургуулийн барилгын барилга угсралтын ажил бүрэн дуусч улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээлгэн өглөө.

Мөн тус 1, 5 дугаар сургуулийн бага сургуулийн гадна инженерийн шугам сүлжээний ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “ДОЦ” ХХК хийж гүйцэтгэн дууссан болно.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Авто Агро” ХХК нь “Орон сууцны 15, 16 дугаар байрны дунд явган хүний зам барих /9-р баг”, “Орон сууцны 12, 13, 14, 17 дугаар байрны дунд явган хүний зам барих”, “Авто машины зогсоол /Хэрлэн сум 2, 9 дүгээр баг” ажлуудыг бүрэн хийж дуусган улсын комиссоор хүлээлгэн өглөө.

4 байшингийн дунд буюу 12, 13, 14, 17 дугаар байрны гадна талд 2 м өргөнтэй, 560 м урт, 15, 16 дугаар байрны гадна явган замын ажил нь 2 м өргөнтэй 280 м урт явган замын ажил болно. Комиссын зүгээс явган зам руу шороо орох хэсгүүдийг янзлах, элсэн чигжээс хийх зэрэг үүрэг даалгавар өгч СӨХ-үүдэд авто машин дайрах, дамнан зогсох зэрэгт анхаарал тавих талаар зөвлөмж өгч ажиллаа.

Авто зогсоол барих ажил нь 13 дугаар байрны ард талд, Бумбат хотхоны зүүн талд Шунхлай шатахуун түгээх байрны баруун урд байршилтай 1 тус бүр нь 40 х 7 м

хэмжээтэй, 14 машин зогсох хүчин чадалтай зогсоолын ажил юм. Тус ажлыг зогсоолын зураасан тэмдэглэгээ хийх үүрэг даалгавар өгч ашиглалтад хүлээн авлаа.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 73 773 588 төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Ган Хэрлэн” зочид буудлын арын хатуу хучилттай замаас “Маршал” хотхон хүртэл 100 м урт хатуу хучилттай авто зам, явган замын хамт барих ажлыг “Авто Агро” ХХК хийж гүйцэтгэн дуусч ашиглалтад хүлээлгэн өгөх хүсэлт гаргаснаар байнгын ашиглалтад орууллаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн 103 000 000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Сэргэлэн сумын орон нутаг судлах танхимын өргөтгөлийн ажлыг “Инса” ХХК хийж гүйцэтгэж байна. Одоогоор барилгын үндсэн хийцийн ажил бүрэн дууссан байдалтай ажил үргэлжилж байна.

Сэргэлэн сумын 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр “ДОЦ” ХХК хийж гүйцэтгэж байна. Барилга угсралтын ажлын эхэлж газар шорооны ажил болон суурийн ажлууд хийгдсэн өргийн материалууд талбайд татагдаад байна. Аймгийн ГХБХБГазраас хяналтын ажлыг гүйцэтгэхдээ түр хашаа барих мэдээллийн самбар байршуулах, бетон зуурмагаас дээж авч лабораторийн шинжилгээнд өгөх зэрэг зөвлөмж шаардлага өглөө.

Цагаан-Овоо сумын 150 хүүхдийн дотуур байрны барилга угсралтын ажлыг Өндөр баганат ХХК хийж гүйцэтгэж байна. Одоогоор барилгын үндсэн хийцийн ажил бүрэн дуусч, гадна болон дотор өргийн ажлууд хийгдсэн, барилгын ажил гүйцэтгэгч компани санхүүжилт удаашралтай гэсэн шалтгаанаар зогсоод байна.

Тус ажлыг гүйцэтгэгч компанийн төлөөллийг хүлээн авч уулзан ажлыг график хугацааны дагуу эрчимжүүлэн үргэлжлүүлэх хүйтний улирлаас өмнө гадна талд хийгдэх ажлуудыг дуусган халаалтыг тавих үүрэг даалгавар заавар зааварчилга өглөө.

2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Баянлуу” ХХК хийж гүйцэтгэсэн Цагаан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын барилгын засварын ажилд байнгын ашиглалтад хүлээн авах комисс ажиллан хүлээн авлаа.

Залуучуудын “Гарааны бизнесийг дэмжих Start-up” төвийг шинээр байгуулахад шаардлагатай тохижилт, тоног төхөөрөмж” ажлын 3-р багц ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Л,Цэрэннадмид захиралтай “Билигт мугсу” ХХК хийж гүйцэтгэн дуусаад байна.

Тус ажлыг хийж гүйцэтгэснээр Залуучуудын “Гарааны бизнесийг дэмжих Start-up” төв бүрэн тохижиж залуучууд шинээр эхлүүлэх бизнесийн санаагаа олох нэг нэгэндээ дэмжлэг үзүүлэх хамтран ажиллах нөхцөл бүрлээ.

Барилга хот байгуулалтын яамны захиалгаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Халхгол сумыг гадна инженерийн шугам сүлжээнд холбох ажил хийгдэж байна. Тус ажилд зураг төслийн зохиогч “Хайдро дизайн прожект” ХХК-ийн захирал Н.Солонго, инженер Б.Ганбат нарын хамт 2 удаа хяналтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Тус ажлыг “Ган-Октаэдр” ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд одоогоор гадна даралттай бохир усны шугамын ажил трассын дагуу газар шорооны ажил хийгдсэн шугам хоолой наах угсрах ажлууд хийгдэж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Халхгол, Баяндун сумдад Нисэх онгоцны буудал барих ажлыг “Стандард рэзидэнс констракшн” ХХК хийж гүйцэтгэн ажиллаа. Тус нисэх онгоцны буудал барих ажлын хүрээнд Халхгол суманд 3000 м урт

нисэх онгоцны нисэх зурвасын хашааны ажил Баяндун суманд 1000м зурвасын хашааны ажил хийгдлээ.

Нисэх зурвасын хашааны ажлыг гүйцэтгэгч компани стандартын дагуу шонд хар мод ашиглан, 2 давхар өргөст тороор 8 удаа татан, шонгийн суурийг хар тосон түрхлэгээр тэрхэн хийж гүйцэтгэлээ.

Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд Сэргэлэн, Халхгол, Хэрлэн сумдад хийгдсэн өвс тэжээлийн агуулахын барилга байгууламжуудыг ашиглалтад хүлээн авсан бол Хөлөнбуйр сумдад “Донж өргөө” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Бизнес эрхлэгчдийг дэмжих төв шинээр барих ажил 70%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

2020 оны 10 дугаар сарын 01-ны өдөр “Ган-Октаэдр” ХХК орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн 10 дугаар багийн ажлын албаны барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажлыг улсын комиссоор авч байнгын ашиглалтад орууллаа. Ус барилга нь техникийн нөхцөлийн дагуу гадна инженерийн шугам сүлжээнд холбогдсон тэнхлэгээрээ 12 х 8 м хэмжээтэй 1 давхар барилга болно.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

